

Биелэлт гаргасан:

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ний

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Ш.АМАР-ОТГОН

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БАЙРШИЛТАЙ
“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН “ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС ДАХИН БОЛОВСРУУЛАХ”
ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2615134/

Хянасан:

НБОГ-ын ХБОБНХ-ийн МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

Улаанбаатар хот

2023 он

Агуулга.

Нэг. Төслийн товч танилцуулга

| | |
|--|-------|
| 1.1.Төслийн товч танилцуулга | 3-4 |
| 1.2. Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт, барилга байгууламж | 4-5 |
| 1.3.Үйлдвэрийн технологи, хүчин чадал | 5-9 |
| 1.4. Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн | 9-14 |
| 1.5. Хог хаягдал | 15-19 |

Хоёр. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | |
|--|-------|
| 2.1. БОМТ-ийн тухайн жилийн төлөвлөгөө | 19-25 |
| 2.2. 2023 оны БОМТ-ний биелэлтийн тайлан | 26-45 |
| 2.3.Хавсралт..... | 46-48 |

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга


| | |
|---|---|
| Төслийн нэр | “Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр”-ийн төсөл |
| Төсөл хэрэгжүүлэгчийн нэр | “Хай Би Ойл” ХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9010001063 |
| Регистрийн дугаар | 2615134 |
| “Аюултай хог хаягдал” цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар | 0000009 |
| Төслийн байршил | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонголон /18135/, 110 тоот |
| Талбайн хэмжээ | 8865м ² |
| Утас | 88119740, 99904034, |
| Төслийн зорилго, ач холбогдол | Үйлдвэрлэл, техникийн зориулалтаар ашиглагдаж хэрэглээний шинж чанараа алдсан нефтийн гаралтай тос, тослох материал болох техникийн хаягдал тос болон гидрийн шингэнийг орчин үеийн технологийн VSEP мембранан шүүлтүүрийн аргаар цэвэршүүлж, шаардлага хангасан M-100 маркийн мазут бэлтгэх зорилготой мөн техникийн хаягдал ажилласан маслыг цэвэршүүлэн, байгаль орчин болоод хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах, аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилготой. |
| Ажиллах хоног | 240 хоног |
| Цахилгаан, ус хангамж | Цахилгаан нь МЗХННУлаанбаатар Төмөр Замын шугам сүлжээнд холбогдсон. Үйлдвэрийн хэрэглээний болон ажилчдын ундны усыг өөрийн эзэмшлийн худгаас хангадаг. |



Зураг 1. Төслийн талбайн байршил (Google Earth)

1.2 Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт, барилга байгууламж:

Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт 8865 метр квадрат талбайг эзлэн үйлдвэр нь байрлана.



Зураг 2. Үйлдвэрийн барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт

Хүснэгт 1. Үйлдвэрийн барилгын талбайн хэмжээ

| № | Нэр | Хэмжээ, м2 |
|------|--------------------------------------|------------|
| 1 | Үйлдвэрийн агуулах | 338.31 |
| 2 | Оффисын барилга | 45.7 |
| 3 | Агуулах | 34.96 |
| 4 | Харуулын байр | 36.2 |
| 5 | Гүний худаг | 16.36 |
| 6 | Трансформатор | 16.61 |
| 7 | Граж | 31.53 |
| 8 | Ногоон байгууламж | 106.65 |
| 9 | Түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах сав | 360.33 |
| 10 | Суурь | 88.71 |
| 11 | Бетон талбай | 65.39 |
| 12 | Сул чөлөөтэй талбай | |
| Нийт | | 8,865.65 |

1.3 Үйлдвэрийн технологи, хүчин чадал

“Хай Би Ойл” ХК нь 2008 оноос хойш Хонг Конгийн Данвелль компанийн үйлдвэрлэсэн VМАТ I-36 системийн техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийг ажиллуулан өөрийн орны уул уурхай болон бусад салбарын техник, тоног төхөөрөмжөөс гарч хаягдаж буй ажилласан маслыг дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэнд оруулж байна.

Хүснэгт 2. Үйлдвэрийн хүчин чадал, үзүүлэлт

| № | Үзүүлэлт | Тоон утга |
|----|---------------------------------------|-----------|
| 1 | Үйлдвэрийн хүчин чадал, тн | 2400 |
| 2 | Төслийн хугацаа, жил | 10 |
| 3 | Төслийн хугацаанд цэвэршүүлэх тос, тн | 14000 |
| 4 | Жилд цэвэршүүлэх ажилласан тос.тн | 1400 |
| 5 | Сард цэвэршүүлэх ажилласан тос.тн | 200 |
| 6 | Жилд сул зогсох сар | 5 |
| 7 | Жилд ажиллах сар | 7 |
| 8 | Жилд ажиллах хоног | 140 |
| 9 | Жилд ажиллах цаг | 1260 |
| 10 | Цаг ашиглалт | 0.88 |
| 11 | Хоногт ажиллах цаг | 9.0 |
| 12 | Хоногт ажиллах бүтээлтэй цаг | 8.0 |
| 13 | Цагийн бүтээл, тн | 1.3 |
| 14 | Хоногийн бүтээл, тн | 10.0 |

Энэхүү дахин боловсруулах үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед жилд 2400тн техникийн хаягдал тос дахин боловсруулах хүчин чадалтай юм. Үйлдвэрийн үйл ажиллагаа дулаан улиралд буюу 4-10 дугаар саруудад нийт 7 сар ажиллана. Энэ үед жилд 1400 тн, 10 жилд 14000 тн ажилласан тос боловсруулна.

Үйлдвэр нь ажилласан тосыг центрифуг, нарийн шүүлтүүр, ууршуулагч болон VSEP мембранан шүүлтүүрийн аргаар цэвэрлэдэг автомат удирдлагын системтэй орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд дараах зарчмаар ажиллана.


Түүхий эд (техникийн хаягдал тос)-ыг үйлдвэр доторхи 25 м³ –ийн савнаас насосоор шахаж 10м³ багтаамжтай тунгаагуур саванд өгнө. Тунгаагуурт ажилласан тосны найрлаганд байх ус, элс, том хэмжээтэй хатуу хольцуудыг тунгаан механик цэвэрлэгээ хийж, найрлагыг нь жигдрүүлэх процесс явагдана. Тунгаагуурын дээд хэсгээс хаягдал тос 2.0м³-ийн багтаамжтай завсрын саванд өөрийн урсгалаар юүлэгдэн орно. Хаягдал ажилласан тосыг завсрын савнаас насосоор соруулан авч центрифугт шахах ба энд төвөөс зугатах хүчний үйлчлэлээр суспенз болон дунд зэргийн хэмжээ, масстай механик хольц нь цэвэрлэгдэнэ. Центрифугээр дамжин 2 дахь цэвэрлэгээ хийгдсэн тос нь дулаан солилцуулагч болон нэрэгчинд тодорхой даралттайгаар өгөгдөнө. Энд хаягдал ажилласан тосны температурыг дээд тал нь 100°С хүртэл нэмэгдүүлж түүний найрлагад байгаа ус, чийгийг ууршуулан конденсацид оруулах процесс явагдана.

Дулаан солилцуулагчаар дамжин халсан тос нь дахин 20 меш буюу 0,8мм хэмжээтэй шүүлтүүрээр шүүгдэн эндээс 3.0м диаметртэй 20м³ багтаамж бүхий конус хэлбэрийн ёроолтой дамжуулах сав гэж нэрлэгдэх тэжээлийн саванд өгөгдөнө. Техникийн хаягдал тосыг халаах үед өндөр температурын үйлчлэлээр хэсэг хугацааны дараа түүнээс ус чийг нь ууршина. Техникийн хаягдал тосыг механик хольцууд болон уснаас салгаснаар өтгөрсөн тос буюу мазутыг үйлдвэрлэнэ.







Зураг 3. VMAT I-36 зургаан багц тоног төхөөрөмж



Зураг 4. VMAT I-36 төхөөрөмжийн технологийн хяналтын самбар



Зураг 5. Түүхий эд болон бүтээгдэхүүн хадгалах, дамжуулах технологийн схем



Зураг 6. Дахин боловсруулах үйлдвэрийн технологийн дараалал

Үйлдвэрийн технологи: “Хай Би Ойл” ХК нь ажилласан тосыг VSEP мембранан шүүлтүүрийн аргаар хөндлөн урсгалт төхөөрөмжийн тусламжтайгаар ажилласан тосыг мембранан шүүлтүүрийн хөндлөн огтлолын дагуу шахаж өгөх арга дээр үндэслэнэ. Энэ нь хатуу хольц хөндлөн урсгалын үйлчлэлээр ийнхүү түрэгдэн зайлах боловч урсгалын хуйралтаар эргээд шүүлтүүрийн гадаргуу дээр цуглардаг. Хөндлөн урсгалт шүүлтүүрт тосыг маш өндөр даралтаар шахаж өгдөг. Шүүх процессийн явцад мембранан шүүлтүүрийн гадаргуу дээр хатуу хольцоос тогтсон давхарга үүсч шүүгдэж буй тосны урсгалыг саатуулж улмаар мембранан шүүлтүүрийн бүтээмжийг их хэмжээгээр бууруулдаг. Өөрөөр хэлбэл хатуу хольц мембранан шүүлтүүрийн гадаргуу дээр хоёрдогч мембранан гадаргууг бий болгодог. Иймээс мембранан шүүлтүүрт ажилласан тосыг нам даралттай урсгалаар өгөх нөхцөл хязгаарлагдмал байдаг.

1.4 Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн

Түүхий эд: Үндсэн түүхий эд нь машин, тоног төхөөрөмжийн (трактор, автомашин, уул уурхайн хүнд машин механизм, комбайн, зам, барилгын ба мод бэлтгэлийн техник, хөдөө аж ахуйн, суурь машин болон бусад) узел ба агрегатуудад ашиглагдаж байсан хаягдал тос, гидрийн шингэн юм. Монголд улсад ажилласан масло буюу техникийн хаягдал тосны чанарт тавих стандарт гэж одоогоор байхгүй байна. Харин ОХУ-д мөрддөг ГОСТ 21046-86 “Нефтепродукты отработанные. Общие технические условия” стандартын шаардлага ёсоор үйлдвэрийн аргаар сэргээлт хийх ажилласан тосыг дараах нормчлогдсон үзүүлэлтүүд бүхий 2 бүлэг (ММО ба МИО) болгон ангилдаг.

Тус үйлдвэр нь “Аюултай хог хаягдал” болох техникийн ажилласан массыг нийслэлийн авто засварын газрууд болон уул уурхайн компаниудаас гэрээний дагуу цуглуулан авч байгаль орчинд ээлтэйгээр дахин боловсруулдаг.



Зураг 7. Байгаль орчинд хаягдаж болзошгүй аюултай хог хаягдал болох техникийн ажилласан тос

Хүснэгт 3. Цуглуулсан техникийн хаягдал тос болон боловсруулалтанд орсон тос

| Түүхий эд | Нэгж | 2022 оны үлдэгдэл тос | 2023 онд цуглуулсан тос | Боловсруулалтанд орсон тосны хэмжээ |
|-----------------------|------|-----------------------|-------------------------|-------------------------------------|
| Техникийн хаягдал тос | литр | 115,699 | 1,366,517 | 1,267,500 |

Хүснэгт 4. Техникийн хаягдал тос цуглуулсан гэрээт газрууд

| | Харилцагч компани | Литр |
|----|-------------------------------|------------------|
| 1 | Бор-Өндөр УБҮ | 24,707 |
| 2 | Делта авт сервис ХХК | 3,400 |
| 3 | Таванбогд ХХК | 57,900 |
| 4 | Петронано ХХК | 22,800 |
| 5 | Таванбогд моторс ХХК | 26,800 |
| 6 | Оюутолгой ХХК | 775,800 |
| 7 | Тавантолгойн түлш ХХК | 1,940 |
| 8 | Грийн Го Ми ХХК | 3,000 |
| 9 | Моннис моторс ХХК | 6,000 |
| 10 | Хэра экуйпмэнт ХХК | 25,800 |
| 11 | Уулс ноён ХХК | 11,100 |
| 12 | Wolf center ХХК | 7,100 |
| 13 | Riko trans ХХК | 4,900 |
| 14 | Хьюндай моторс монгол ХХК | 4,700 |
| 15 | Шунхлай ХХК | 3,000 |
| 16 | Ач буян ХХК | 2,400 |
| 17 | Мак засварын төв | 1,300 |
| 18 | Жэйд ХХК | 18,400 |
| 19 | Түвшин саруул ХХК | 2,900 |
| 20 | Хүслэн сүбээдэй ХХК | 10,600 |
| 21 | Автосервис комплекс ХХК | 4,500 |
| 22 | Мөнхийн төгс мичид ХХК | 6,600 |
| 23 | Онно трейд ХХК | 7,200 |
| 24 | Бэрлэг майнинг ХХК | 1,200 |
| 25 | Аглаг хангайн уулс ХХК | 4,000 |
| 26 | Шагдаржав | 6,450 |
| 27 | Паблик сервис ХХК | 72,000 |
| 28 | Батбродерс майнинг ХХК | 1,800 |
| 29 | Цагдаагийн авто бааз | 1,600 |
| 30 | Тагнуулын Ерөнхий газар | 800 |
| 31 | Коронус авто сервис ХХК | 1,400 |
| 32 | Батхулэг ХХК | 5,800 |
| 33 | Топ моторс ХХК | 4,100 |
| 34 | Барловорлд майнинг ХХК | 32,000 |
| 35 | Эрдгео ХХК | 1,000 |
| 36 | Петротрак ХХК | 3,500 |
| 37 | Иргэний нисэхийн үндэсний төв | 2,000 |
| 38 | Б. Цолмон | 15,000 |
| 39 | Тод ундарга ХХК | 9,500 |
| 40 | Баян айраг ХХК | 56,450 |
| 41 | Элемент ХХК | 7,600 |
| 42 | Шарын гол ХК | 83,200 |
| 43 | Автоланд ХХК | 4,900 |
| 44 | МСМ ХХК | 18,000 |
| 45 | Монрок ХХК | 4,000 |
| | Нийт | 1,366,517 |


Хүснэгт 5. Боловсруулалт хийгдэх ажилласан тосны нормчлогдсон үзүүлэлтүүд

| Үзүүлэлтийн нэр | Нормчлогдсон үзүүлэлтүүд | | Шинжлэх арга |
|---|--------------------------|---------------|-------------------------------|
| 20°С ба 50°С үеийн кинематик зууралдлага (Cст) | 40<35 | 13-40 5-35 | ГОСТ 26378.3-84 ГОСТ 33-82 |
| Задгай тиглед тодорхойлсон асах температур, °С, доошгүй | 100 | 120 | ГОСТ 26378.4-84 |
| Механик хольцын массын даль, %, ихгүй | 1 | 1 | ГОСТ 26378.2-84 |
| Усны масс доль, %, ихгүй | 2 | 2 | ГОСТ 26378.1-84 |
| Бохирдлын агуулга | Байх ёсгүй | | ГОСТ 26378.2-84 |

1.4.2 Эцсийн бүтээгдэхүүн

Тус үйлдвэрийн технологиор автомашины хөдөлгүүрийн хаягдал тос болон гидрийн шингэнийг цэвэршүүлэн М-100 маркийн мазут үйлдвэрлэдэг байна. Дахин боловсруулсан тос буюу мазутыг уурын зуух болон цахилгаан станц, асфальт бетон зуурмагийн үйлдвэр, халаагуур эсвэл хайлуулах зуух, цементийн зуух гэх мэт үйлдвэрлэлд галалгааны түлш хэлбэрээр хэрэглэдэг.


Мазутад тавигдах техникийн нөхцөлийг “Газрын тосны бүтээгдэхүүн, Мазут Техникийн ерөнхий шаардлага MNS 3828:2008” стандартад нийцүүлдэг. Уг стандартад барьцалдах чанараараа хөнгөн түлш болох флотын мазут Ф-5, Ф-12 мөн дунд ангиллын М-40 болон хүнд ангиллын М- 100 маркийн зуухны мазут гэж тус бүр ангилсан байдаг.



АМБЕР ХХК

лаб. инспекци

Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний
MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори



СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №02101/23

| ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | | |
|--|-------------------------------|----------------------------|
| Дээж ирүүлсэн байгууллагын нэр | Хай Би Ойл ХК | |
| Дээжийг авсан газар | Улаанбаатар, Монгол | |
| Дээжийн төрөл | Мазут | |
| Дээж авсан объект | Сав | |
| Дээж авсан ажилтан /Нэр, албан тушаал/ | Хай Би Ойл ХК-ийн ажилтан | |
| Дээжийн хэмжээ | 1.2 литр | |
| Дээжийн лашны дугаар | - | |
| Дээжийн нэмэлт тайлбар | - | |
| Дээж авсан огноо:2023.04.27 | Хүлээн авсан огноо:2023.04.27 | Шинжилсэн огноо:2023.04.28 |

СОРИЛТЫН ҮР ДҮН

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Сорилт гүйцэтгэсэн стандарт | Норм MNS 3828:2008 /M100/ | Үр дүн |
|---|--------------------|-----------------------------|---------------------------|------------|
| 1 15 ⁰ С дахь хувийн жин | г/см ³ | MNS 0481 | - | 0.8804 |
| 2 Кинематик зууралдлага 50 ⁰ С-т 100 ⁰ С-т | мм ² /с | MNS 0480 | - | 51.735 |
| | | | 50.0 ихгүй | 8.133 |
| 3 Механик хольцын хэмжээ | % | MNS 0322 | 1.5 ихгүй | байхгүй |
| 4 Усны хэмжээ | % | MNS 0332 | 1.0 ихгүй | 1.931 |
| 5 Задгай тигельд дөл үүсгэх хэм | ⁰ С | MNS 0328 | 110.0 багагүй | 133.0 дээш |
| 6 Царцах хэм | ⁰ С | MNS 3192 | /25.0/ ихгүй | /-39.0/ |
| 7 Өнгө | - | MNS ISO 2049 | - | хар |

Шинжилгээ хийсэн химич

Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч



Б.Мандахнаран


Г.Энхтунгалаг

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251

Энэхүү тайлан нь тухайн дээжний хувьд хүчинтэй.
Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

000128863

Зураг 7. Мазут шинжилгээ



АМБЕР ХХК

лаб. инспекци
Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний
MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори



СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №03104/23

| ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | | |
|--|-------------------------------|----------------------------|
| Дээж ирүүлсэн байгууллагын нэр | Хай Би Ойл ХК | |
| Дээжийг авсан газар | Улаанбаатар, Монгол | |
| Дээжийн төрөл | Мазут | |
| Дээж авсан объект | Сав | |
| Дээж авсан ажилтан /Нэр, албан тушаал/ | Хай Би Ойл ХК-ийн ажилтан | |
| Дээжийн хэмжээ | 0.9 литр | |
| Дээжийн лацины дугаар | - | |
| Дээжийн нэмэлт тайлбар | - | |
| Дээж авсан огноо:2023.06.21 | Хүлээн авсан огноо:2023.06.22 | Шинжилсэн огноо:2023.06.22 |

СОРИЛТЫН ҮР ДҮН

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Сорилт гүйцэтгэсэн стандарт | Норм MNS 3828:2008 /M100/ | Үр дүн |
|---|--------------------|-----------------------------|---------------------------|---------|
| 1 15 ⁰ С дахь хувийн жин | г/см ³ | MNS 0481 | - | 0.8804 |
| 2 Кинематик зууралдлага 50 ⁰ С-т 100 ⁰ С-т | мм ² /с | MNS 0480 | - | 97.83 |
| | | | 50.0 ихгүй | 12.45 |
| 3 Механик хольцын хэмжээ | % | MNS 0322 | 1.5 ихгүй | байхгүй |
| 4 Усны хэмжээ | % | MNS 0332 | 1.0 ихгүй | байхгүй |
| 5 Задгай тигельд дөл үүсгэх хэм | ⁰ С | MNS 0328 | 110.0 багагүй | - |
| 6 Царцах хэм | ⁰ С | MNS 3192 | /25.0/ ихгүй | /-32.0/ |
| 7 Өнгө | - | MNS ISO 2049 | - | хар |

Шинжилгээ хийсэн химич

Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч



Б.Мандахнаран

Б.Адъяа

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251

Энэхүү тайлан нь тухайн дээжний хувьд хүчинтэй.
Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

000133183

Зураг 8. Мазутын шинжилгээ

1.5 Хог хаягдал

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллаж байна. Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах (хоолны үлдэгдэл, цаас хайрцаг сав баглаа боодол) хүмүүсийн хэрэглэж байсан зүйлс багтана. Нийт 8 хүн ажиллах бөгөөд жилд 140 хоног ажиллана гэж тооцвол өдөрт 4 кг, сард 120кг (8 хүн хоног 0,5кг хатуу хог хаягдал/хоногт*30 хоног), жилд 840кг хог хаягдал гарахаар байна. Харин үйлдвэрээс гарах саарал усыг 3 дамжлагат тунгаах саванд хийсний дараа хөргөлтийн системд дахин ашиглах байна.



Зураг 9. Хог ачилт

БАТЛАВ
СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Б.ЭНХТӨГТӨХ
2023 оны 4 сарын 4 өдөр

БАТЛАВ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ТОХИЖИЛТ ТЭВЭРЛЭГЭЧ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНБААТУГ
ЗАХИРАЛ Т.ВАРДАНДОРЖ
9021080347
5680174 & СБТ15015
Дугаар 1130

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ:
ААН БАЙГУУЛЛАГА
“Хай Би Ойл” ХК
ЗАХИРАЛ
Улаанбаатар хот

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ячих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 40 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан “Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам”, Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 10/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

2.2 Энэхүү гэрээг

НЭГ ТАЛААС: Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс /цаашид татварын байцаагч гэх/, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын даргадах “Тохижилт I тэвэрлэгч Үйлчилгээ” ОНБААТУГ /цаашид тэвэрлэгч гэх/

НӨГӨӨ *Хай Би Ойл* ТАЛААС: иргэн, аж ахуй нэгж, элсэн байгууллага /догоор зурвас/ *Дашин болортуул* үйл ажиллагааны чиглэлтэй /цаашид үйлчлүүлэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 2023 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн 2023 оны 12-р сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

ДЭРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сас бүрийн 25-ны дотор гэрээнд заасан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хурван авах эрхтэй.

4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлээс 73 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хийх эрхтэй.

4.3 Аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тээвэрлэгч Байгууллагатай тооцро нийлж байх үүрэгтэй.

4.4 Татварын байцаагч нь аж ахуй нэгж байгууллага бүрээс хог хаягдлын хураамжийг тогтсон хугацаанд, тогтмол хурваж тээвэрлэгч байгууллагын ажилт хийх боломжийг хангах үүрэгтэй.

4.5 Аж ахуй нэгжээс нэхэмжлэлээр хураасан хог хаягдлын хураамжийн задаргааг тээвэрлэгч байгууллагад дараа сарын 3-ны дотор аж ахуй нэгж, байгууллага гаргаж өгөх.

ТАВ. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Тэвэрлэлт хийсэн аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Татварын хэлтэстэй тооцро нийлж байх үүрэгтэй.

5.2 Гэрээний үнийн дүн болон ачуулж байгаа хог тэвэрлэлтийн зарлал бодит байдал дээрээ хоорондоо нийцэхгүй тохиолдолд тэвэрлэгч байгууллагаас татварын хэлтэст Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ийн 10/01 дугаар тогтоолд заасан тарифын дагуу үнийн санал гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5.3 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг тээвэрлэгчтэй холбоотой гомдол гаргавал тооцоо нийлж, протокол үйлдэж, тэвэрлэлтийн баримтаар нотлохдоогүй бол хохирлыг тээвэрлэгч байгууллага барагдуулах үүрэгтэй.

5.4 Хог хаягдлын ачилт хийсэн хуудас, нэхэмжлэлийг сар бүрийн 20-ны дотор Татварын хэлтэст өгч, ачилт хийсэн аж ахуй нэгж, иргэн, албан байгууллагын мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хогийг тээвэрлэхгүй.

ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтсон хогийн цэгт хаях болон овор хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урьд өдөр нь тээвэрлэгч байгууллагын 70000818 дугаарын утсанд ажлын цагаар дуудлага өгнө. Гэрээнд заасан тарифийн дагуу тогтмол рейсийн тоогоор тээвэрлүүлэх.

6.2 Татварын байцаагчаас хог хаягдлын хураамж тушаасан баримт, Тээвэрлэгч байгууллагаас хог хаягдлыг ачуулсан баримтыг шаардан авах эрхтэй.

6.3 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцаасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуй нэгж байгууллага болон иргэн өөрөө хариуцна.

6.4 Үйлчлүүлэгч нь тогтсон хугацаанд татварын байцаагчид гэрээний дагуу хог хаягдлын хураамжийг төлж байх, Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд, зориулалтын цэгээс, уут саванд хийсэн хог хаягдлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

6.5 Ажиллаагүй гэсэн шалтгаанаар хог хаягдлын хураамж төлөөгүй аж ахуй нэгж, иргэн, албан байгууллага тухайн харьяалагдах хорооноос ажиллаагүй гэсэн албан бичиг авч баримтжуулах үүрэгтэй.

6.6 Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасны дагуу шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байх үүрэгтэй.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1 Эрх зүйн баримт бичиг болон стандартад өөрчлөлт орсон тухайн цаг үед гэрээ байгуулсан талуудаас санал оруулах нь нээлттэй.

7.2 Үйлчлүүлэгч /1рейсийн/ үйлчилгээний хураамжийг Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01 дугаар тогтоолоор тогтоосон тарифын дагуу /сар бүрийн.....төгрөг/, /улиралд.....төгрөг/, /жилд.....төгрөг/, /захиалгаар 150,000 төгрөг/ төлбөрийг төлнө.

7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаврыг үүсгэн банкинд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хогийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувиар алданги тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан дүүргийн "Тохжилт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНӨААТҮГ" төлөөлж:
Албан тушаал: Хуулийн зөвлөх
Нэр: Ж. Амарсанаа
Гарын үсэг /...../

Аж ахуй нэгж, байгууллагыг төлөөлж:
Албан тушаал: 18-80
Нэр: С. Доржпүрэв
Гарын үсэг /...../ Утас: 99904034, 80010277
Хаяг: СХД-дс-рхороо
Солстолох 18/35 Төвчорооны
300 59 15006

88934737 - Мөлөөл.
80084608 - Диспетчир

Зураг 10. Хог хаягдлын гэрээ

1.5.2 Унд ахуйн хэрэглээний ус: Үйлдвэрт нийт 8 хүн ажиллана. Иймд ундны усыг байгаль орчны Сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын хавсралтын дагуу тооцоо хийдэг.

Хүснэгт 6. Усны хэрэглээний хоногийн дундаж норм

| № | Усны хэрэглээний нэр, төрөл | Ус хэрэглээний хоногийн дундаж норм, л/хон |
|---|--|--|
| 1 | Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангагддаг гэр хороолол | 20 |

8*20-160л/хоног буюу 0,16м³/хон болж байна.

Жилд нийтдээ 140 хоног ажиллана гэж тооцохоор нийт 22.4м³ ус хэрэглээнд ашиглана.

Хүснэгт 7. Хог хаягдлын дахин ашиглалт

| Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл | | Дахин ашиглалт | Устгал | Дахин боловсруулах, ашиглах | Зайлуулах арга хэмжээ |
|---------------------------------------|----------|-------------------------|--------|-----------------------------|--|
| Ахуйн | 20 03 01 | Гал тогооны хаягдал | + | - | Дахин ашигладаг иргэн, аж ахуйн нэгжид нийлүүлэх |
| | 20 01 03 | | | | |
| | 19 12 01 | Цаас хайрцаг | + | + | |
| Үйлдвэрээс | 05 01 04 | Асгарсан тос | - | + | Тусгай зөвшөөрөлтэй компаниар |
| | 05 01 08 | Тосны лаг | - | + | |
| | 05 01 99 | Төмрийн үлдэгдэл, үртэс | - | + | |
| | 16 07 99 | Саарал ус | + | - | Үйлдвэрийн хөргөлтийн усандаа ашигладаг |

| | | | | | | |
|---------|--|--------------|---|---|--|-------------------------------|
| Шинжлэг | | Унд ахуйн ус | + | - | | Тусгай зөвшөөрөлтэй компаниар |
| | | | | | | |

ХОЁР. 2021 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

“Хай Би Ойл” ХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцан хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино.

Хүснэгт 1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал

| № | Байгаль орчны менежмент төлөвлөгөөний задаргаа | 2023 оны жилийн зардал, төгрөг |
|---|--|--------------------------------|
| 1 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал | 68,150,000 |
| 2 | Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал | 1,075,400 |

| | | |
|---|---|------------|
| 3 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт хийх ажлын зардал | 2,400,000 |
| Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал | | 73,625,400 |

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 2. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын задаргаа

| № | Хийгдэх төлөвлөгөөт ажилууд | Зардал, төг |
|---|---|-------------|
| 1 | Бохирдсон хөрсийг хусаж цэвэрлэж саармагжуулалт хийх бүтээгдэхүүн ачиж буулгах эсткад буюу АХХ цулуулах талбайг бетонджуулах | 18,000,000 |
| 2 | Аянга зайлуулагч болон тоног төхөөрөмжийн газардуулга эсэргүүцлийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулалт хийх | 16,000,000 |
| 3 | 8 ширхэг түүхий эд болон, эцсийн бүтээгдэхүүнийг хадгалах агуулахаа үл нэвчих грунт, будгаар будах, бохирдуулахаас сэргийлэх | 15,000,000 |

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Цаашид нэмж барилга байгууламж барихдаа дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах, хатуу, шингэн хог хаягдлыг хэт хуримтлуулахгүй байх, гэрэлтүүлэг болон ногоон байгууламжийг сайжруулан зам талбайг хатуу хучилттай болгохдоо Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ын дагуу иргэн, аж ахуй нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 20 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх шаардлагыг биелүүлэх ба эзэмшлийн болон өмчлөлийн газрын 20 хувиас доошгүй талбайд мод тарьж, зүлэгжүүлэх нөхөн сэргээлт хийх ажлын нийт зардал нь 4,400,000 төгрөг төсөвлөсөн.

Хүснэгт 3. 1м² талбайд нөхөн сэргээлт хийх зардал

| Зүлэг тарих/үйлдвэрийн хашаанд/ | | | |
|---------------------------------|--------------|-------------|------------------|
| | Ургамлын нэр | Тоо, ширхэг | Зүлэгний үнэ |
| 1 | Хайлаас | 1,200 | 750,000 |
| 2 | Улиас | 85 | 500,000 |
| 3 | Хус | 2 | 600,000 |
| 4 | Гацуур | 6 | 480,000 |
| 5 | Агч | 4 | 380,000 |
| 6 | Зэмэг | 4 | 350,000 |
| 7 | Борита | 2 | 350,000 |
| 8 | Хар шороо | - | 1,500,000 |
| 9 | Бордоо | 2 | 100,000 |
| | Нийт | 1303 | 4,210,000 |

3. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу хог хаягдал

Үйлдвэрийн процессын явцад хатуу хог хаягдал гарахгүй бөгөөд харин ажиллагсдын ахуйн хэрэглээнээс гарах хуурай хатуу хог хаягдал(хоолны үлдэгдэл, цаас, хайрцаг, сав баглаа боодол)

хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлс багтана.

Нийт 8 хүн ажиллах бөгөөд жилд 240 хоног өдөр ажиллана гэж тооцвол өдөрт 4 кг, сард 120кг (8 хүн x 0.5кг хатуу хог хаягдал/хоног x 30 хоног), жилд 960кг хог хаягдал гарахаар байна.

Ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлыг өөрийн хогийн битүү саванд хуримтлуулан хадгалах ба хуримтлагдсан хогийг сар бүр Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай байгуулсан гэрээний дагуу ачуулж байхаар төлөвлөсөн.

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, мян.төг | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|-------------------------------|--|--|
| Хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, тэмдэгжүүлэх | Үйлдвэрийн хэмжээнд | Үйл ажиллагааны зардалд тусгах | Хог хаягдлын тухай хуулийн 10.2.8 заалт хэрэгжинэ |
| Энгийн хог хаягдалыг сард 1 удаа хог хаягдлаа ачуулж байх | | 1 удаагын ачилт 150,000₮ | Хог хаягдлын тухай хууль 10.2.3 заалт Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21.3 заалт |
| Нийт зардал | | | 150,000 |

4. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, осол, аюулын үед авч хэрэгжүүлэх үүднээс төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагааны хүрээнд эрсдлийн менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллаж, тохиолдож болзошгүй эрсдлийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний зардалд зориулан “Эрсдлийн сан” үүсгэх ба байнгын бэлэн байлгах шаардлагатай.

Хүснэгт 5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нэгжийн зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|-------------------------------------|--|--------------------------|---------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | Аюулгүй ажиллагааны | Эрсдлийн сан үүсгэх | Үйлдвэрийн орчинд | 1,500,000₮ | Төслийн хугацаанд | - |

| | | | | | | |
|-------------|-----------|--|--|------------|--|--|
| | чиглэлээр | | | | | |
| Нийт зардал | | | | 1,500,000₮ | | |

5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилсан тооцоо | Хэрэгжих хуваарь, хугацаа | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|-------------------|---------------------------|---------------------------|---|
| 1 | БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх | Дотоод зардлаар | Төсөл хэрэгжих хугацаанд | Компанийн удирдлага | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31 дүгээр зүйл хэрэгжинэ |
| 2 | Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах асуудлаар орон нутгийн төр захиргааны байгууллага болон эрх бүхий ажилтнуудтай байнга харилцан хамтарч ажиллах | | | | |
| 3 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх | | Жил бүрийн 11-р сард | | “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14.1.2 заалт хэрэгжинэ |

6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хуваарь

Хүснэгт 7. БОМТ-г эрх бүхий байгууллага, олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тоо | Хариуцсан зохион байгуулах албан, тушаалтан ажилтан | Зохион байгуулах хэлбэр |
|---|--|--|--|--|---|---|
| 1 | Дүүргийн иргэд, Засаг дарга болон иргэдийн хурал | Хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэх санал авах | БОМТ-ний хэрэгжилт-ийн тухай | Жил бүрийн 4 болон 10 сард | Менежер | Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар санал авах |
| 2 | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Ажлын тайланг хянуулж, төлөвлөгөөг батлуулах | Төслийн үйл ажиллагаа наас хүрээлэн буй орчин, ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний чиглэлээр хийгдэж буй ажил | Жил бүрийн 11-р сарын 01, 12-р сарын 31-с өмнө | | Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх |

7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд, ЗДХ | Хяналтын цэгийн байршил | Давтамж | Нэгж үнэ, мян.төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|--|-------------------------|---------|-------------------|---|
| Агаар, тоосжилт | | | | |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл, СО | Үйлдвэрийн | Жилд 2 | 72,000*2 | “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 Хот |


| | | | | |
|--------------------------------------|------------------------|-------------|----------------------|--|
| Хүхрийн давхар исэл, SO ₂ | гадна ба дотоод орчин | удаа | 144,000 | суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 17.2.3.16-88 Агаар мандал. Сорьц авахад тавих үндсэн шаардлага MNS 3384-82 Хөдөлмөрийн нөхцөл хүчин зүйлийн ангилал, тодорхойлолт, үнэлэх шалгуур нөхцөл тогтоох аргачлал MNS 12.100-91 Ажлын бүсийн агаар эрүүл ахуйн шаардлага MNS 12.013-91 Ажлын байрны бичил цаг уурын хэмжилт хийх арга MNS 12.054-91 Ажлын байр агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох MNS 12.055-91 |
| Азотын ислүүд NO _x | | | | |
| Нийт тоос, TSP | | | | |
| Хөрс | | | | |
